

**НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН  
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ**

2022/06/25-2022-09-25

№	Өргөдөл гомдлын агуулга	Нийт тоо	Хэлбэр					Агуулга					Шийдвэрлэж хариу өгсөн			Шийдвэрлэж байгаа		
			амаар	бичгээр	утсаар	Цахим хэлбэрээр	Дээд байгууллагаас ирсэн	талархал	Санал	хүсэлт	гомдол	мэдэгдэл	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа хэтэрч хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн	
1	Цахим системд бүртгэгдсэн	85		85				0		85			85					
2	Цахим системд бүртгэгдээгүй	0																
<b>Нийт</b>		85		85				0		85			85					

ХЯНАСАН  
ДАРГА



Ш.МӨНХЦЭЦЭГ

МЭДЭЭ ГАРГАСАН  
НИЙГМИЙН АЖИЛТАН

Б.ЦОГЗОЛ

## НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВД 2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ ТАЙЛАН

2022 оны 09 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

2022 оны 3 дугаар улиралд иргэдээс 85 өргөдөл ирснийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж UB ERP систем дэх Өргөдөл гомдлын дэд системд бүртгэсэн. Дээрх өргөдөл, хүсэлтийн 90,5% нь төвийн байранд орох, 6,5% гарах хүсэлт, 3%-нь иргэний бичиг баримттай холбоотой хүсэлт байна.

2021 оны 3 дугаар улиралд иргэдээс 24 хүсэлт, 0 талархал, гомдол 0 ирүүлж байсан нь өмнөх оны энэ үетэй харьцуулахад хүсэлтийн тоо өссөн дүнтэй байна.

Тус төв нь нийслэлийн хэмжээнд тэнүүчлэн амьдарч байгаа иргэдийг хүлээн авч нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд дээрх иргэд нь регистрийн дугаараа мэдэхгүй, холбогдох утасгүй, тодорхой оршин суух хаяггүй байдаг нь ERP програмд шивэхэд хүндрэл үүсгэж байна.

Мөн дээрх иргэд нь бичиг үсгийн боловсрол муу, сэтгэцийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, архинд донтох өвчтэй, гар утас ашигладаггүй, орон гэргүй учраас тодорхой оршин суух хаяггүй байдгаас шалтгаалан бичсэн өргөдөл шаардлага хангахгүй байх шалтгаан болдог. /Төрийн албан ёсны хэлээр өргөдөл бичих чадваргүй, үг үсгийн алдаа ихтэй/

Нийгмийн ажилтнууд эдгээр иргэдийг хүлээн авч, бүртгэл судалгаа хөтлөн, нийгмийн халамжийн анхан шатны үйлчилгээ үзүүлсний дараа /усанд оруулах, дотуур гадуур хувцсыг нь солих, халуун хоолны үйлчилгээнд хамруулах/ бүртгэлийн анкет хөтлөн, өргөдөл хүсэлтийг хүлээн авч байна.

Өргөдлийн тоо өссөн нь их засварын ажил хийгдэж түр хоноглох байрны орчин, нөхцөл сайжирсан, covid-19 цар тахлын дэгдэлт буурсантай холбоотой байна.

Өргөдөл, гомдол хариуцсан ажилтан нь холбогдох байгууллагаас зохион байгуулагдсан сургалтанд хамрагдаж, ажилтнуудад заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр Хурлаас өгсөн үүрэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 03/3144 дугаартай албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу төвийн удирдлага, хамт олонд сар бүр иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг танилцуулж, өргөдөл, гомдлыг өдөрт нь хүлээн авч танилцан шийдвэрлэж байна.

Тайлант хугацаанд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол үгүй, саналын шинжтэй өргөдөл ирүүлээгүй бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 цаг 32 минут зарцуулсан байна.

2022 оны 3 дугаар улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг байгууллагын цахим хуудсаар мэдээлж, даргын дэргэдэх зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын хурлаар хэлэлцүүлсэн болно.

ТАНИЛЦСАН:  
ДАРГА



ТАЙЛАН, МЭДЭЭ ГАРГАСАН:  
НИЙГМИЙН АЖИЛТАН

Ш.МӨНХЦЭЦЭГ

Б.ЦОГЗОЛ